



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунтуяа

Утас: 70350757 Цахим хаяг: oyuntuya0428@yahoo.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	18
3.1 Ерөнхий зүйл	18
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	18
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	18
3.4 Материаллаг байдал.....	18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	20
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 42
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 18 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
П.БАТБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,155,309.61	70,019,498.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
35	БАРАА МАТЕРИАЛ	60,155,309.61	70,019,498.93
351	Түүхий эд материал	19,393,666.92	21,584,156.24
35110	Тусгай зориулалттай материал	19,393,666.92	21,584,156.24
35130	Эм боох материал		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	40,761,642.69	48,435,342.69
35410	Бичиг хэргийн материал	727,600.00	1,368,450.00
35420	Аж ахуйн материал	40,034,042.69	47,066,892.69
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,881,531,890.99	1,835,498,257.04
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
371	Урт хугацаат хадгаламж	-	-
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,881,531,890.99	1,835,498,257.04
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,377,496,890.91	1,331,600,756.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,297,546,730.79	1,297,546,730.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54,298,346.88)	(81,447,520.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143,217,317.00	147,282,817.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,075,391.11)	(128,094,186.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,749,725.28	49,749,725.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,574,857.59)	(40,216,438.53)

39209	Зам, гүүрийн байгууламж	114,291,215.74	114,291,215.74
39210	Хуримтлагдсан элэгдэл	(16,359,502.32)	(27,511,586.33)
393	Биет бус хөрөнгө	504,035,000.08	503,897,500.12
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(274,999.92)	(412,499.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	503,760,000.00	503,760,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,941,687,200.60</u>	<u>1,905,517,755.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
42231	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>775,569,576.30</u>	<u>739,400,131.67</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	775,569,576.30	739,400,131.67
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	(263,811,152.04)	(299,980,596.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(263,811,152.04)	(263,811,152.04)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,169,444.63)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,039,380,728.34	1,039,380,728.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>775,569,576.30</u>	<u>739,400,131.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	829,289,869.26	833,422,590.59
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
118304	Нохойны албан татвар		

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,565,269.26	5,390,443.32
120	Нийтлэг татварын бус орлого	29,565,269.26	5,390,443.32
120001	Хувьцааны ногдол ашиг		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,809,369.26	5,390,443.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	183,400.00	289,054.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,625,969.26	5,101,389.32
120005	Түрээсийн орлого		
120009	Бусад орлого	755,900.00	-
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	799,724,600.00	828,032,147.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	769,274,900.00	783,041,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	769,274,900.00	783,041,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,670,847.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,600,847.27
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,449,700.00	36,319,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,449,700.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	36,319,800.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	854,470,325.62	869,592,035.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,470,325.62	869,592,035.22

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	828,998,680.62	833,368,264.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648,761,169.00	651,984,500.00
210101	Үндсэн цалин	546,107,806.66	397,296,630.00
210102	Нэмэгдэл	58,423,035.98	204,811,852.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,156,934.00	1,597,300.00
210104	Урамшуулал	43,073,392.36	48,278,718.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,345,144.00	87,164,801.00
210201	Тэтгэврийн даатгал	56,524,244.00	60,909,901.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,455,200.00	6,563,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,164,200.00	5,251,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,291,000.00	1,312,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,910,500.00	13,127,500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,020,863.00	34,006,630.00
210301	Гэрэл, цахилгаан	1,808,993.00	2,400,886.00
210302	Түлш, халаалт	20,888,361.00	25,415,904.00
210303	Цэвэр, бохир ус	4,323,509.00	6,189,840.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	15,381,449.65	6,865,150.00
210401	Бичиг хэрэг	1,342,900.00	3,337,650.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,723.00	98,100.00
210404	Ном, хэвлэл	383,202.15	25,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,154,776.00	1,423,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,198,300.00	1,981,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	4,204,548.50	-

2105	Нормативт зардал		717,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,000.00	717,150.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	244,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	825,100.00	1,022,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	825,100.00	1,022,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	430,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	-	430,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,230,054.97	51,177,633.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	820,100.00	495,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,527,930.00	583,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,882,024.97	50,099,133.95
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,471,645.00	36,223,770.27
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,441,400.00	28,382,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,706,100.00	27,486,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,735,300.00	896,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,426,508.00	7,353,300.27
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,426,508.00	7,353,300.27
213304	Хөрөнгийн		

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,603,737.00	488,370.00
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,603,737.00	488,370.00
213404	Хөрөнгийн		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(25,180,456.36)	(36,169,444.63)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		
230001	Эргэж төлөгдөх зээл		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(25,180,456.36)	(36,169,444.63)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(238,064,795.68)	1,967,433,556.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(238,064,795.68)	1,967,433,556.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,746,356.36)	(25,746,356.36)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(263,811,152.04)	1,941,687,200.60
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(263,811,152.04)	1,941,687,200.60

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(263,811,152.04)	1,941,687,200.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(36,169,444.63)	(36,169,444.63)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,166,117,624.30	1,039,380,728.34	(299,980,596.67)	1,905,517,755.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>808,269,582.00</u>	<u>831,392,093.27</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,390,800.00	289,054.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,390,800.00	289,054.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	183,400.00	289,054.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	183,400.00	289,054.00
120008	Монгол банкны ашиг		
120009	Бусад орлого	2,207,400.00	-
124	Зээлийн орлого	-	-
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	805,878,782.00	831,103,039.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	769,274,900.00	783,041,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	769,274,900.00	783,041,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,670,847.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,600,847.27

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,449,700.00	36,319,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,449,700.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	36,319,800.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,154,182.00	3,070,892.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,154,182.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	3,070,892.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>809,337,082.00</u>	<u>830,192,093.27</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	809,337,082.00	830,192,093.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	775,577,055.00	790,897,431.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648,761,169.00	651,984,500.00
210101	Үндсэн цалин	546,107,806.66	397,296,630.00
210102	Нэмэгдэл	58,423,035.98	204,811,852.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,156,934.00	1,597,300.00
210104	Урамшуулал	43,073,392.36	48,278,718.00
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,345,144.00	87,164,801.00
210201	Тэтгэврийн даатгал	56,524,244.00	60,909,901.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,455,200.00	6,563,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,164,200.00	5,251,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,291,000.00	1,312,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,910,500.00	13,127,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,020,863.00	34,006,630.00
210301	Гэрэл, цахилгаан	1,808,993.00	2,400,886.00
210302	Түлш, халаалт	20,888,361.00	25,415,904.00
210303	Цэвэр, бохир ус	4,323,509.00	6,189,840.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	11,560,449.00	6,188,600.00
210401	Бичиг хэрэг	395,800.00	1,430,900.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,723.00	1,823,100.00
210404	Ном, хэвлэл	358,400.00	239,500.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	9,349,076.00	902,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,359,450.00	1,792,800.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		
2105	Нормативт зардал	1,012,600.00	1,402,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,700.00	504,200.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	734,900.00	898,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	825,100.00	1,824,800.00
210604	Урсгал засвар	825,100.00	1,824,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	430,000.00
210702	Дотоод албан томилолт	-	430,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,051,730.00	7,895,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	820,100.00	495,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,231,630.00	7,400,300.00
211	ХҮҮ	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,760,027.00	39,294,662.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,522,382.00	31,452,992.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	3,070,892.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,154,182.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,632,900.00	27,486,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,735,300.00	896,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,426,508.00	7,353,300.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,426,508.00	7,353,300.27
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,603,737.00	488,370.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,603,737.00	488,370.00
213404	Хөрөнгийн		

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,207,400.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,207,400.00	-
213504	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1,067,500.00)</u>	<u>1,200,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,200,000.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж	-	1,200,000.00
223001	Бусад хөрөнгө		
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,200,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,067,500.00)	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	800437500.00	789877755.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800437500.00	789877755.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785586500.00	775289555.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648761200.00	648761169.00
210101	Үндсэн цалин	400493500.00	546107806.66
210102	Нэмэгдэл	200449400.00	58423035.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4000000.00	1156934.00
210104	Урамшуулал	43818300.00	43073392.36
210105	Гэрээт ажлын хөлс		

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85583600.00	82345144.00
210201	Тэтгэврийн даатгал	59762700.00	56524244.00
210202	Тэтгэмжийн даатгал	6455200.00	6455200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5164200.00	5164200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1291000.00	1291000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12910500.00	12910500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28842700.00	27020863.00
210301	Гэрэл, цахилгаан	2908400.00	1808993.00
210302	Түлш, халаалт	21293000.00	20888361.00
210303	Цэвэр, бохир ус	4641300.00	4323509.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	14183700.00	11560449.00
210401	Бичиг хэрэг	395800.00	395800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	762,700.00	97,723.00
210404	Ном, хэвлэл	358,400.00	358,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,297,000.00	9,349,076.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,369,800.00	1,359,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	1,012,600.00	1,012,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,700.00	277,700.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	734,900.00	734,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,607,000.00	825,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,607,000.00	825,100.00
2107	Томилолт, зочны зардал	267,500.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	267,500.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	505,900.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	505,900.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,822,300.00	3,764,230.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	532,600.00	532,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,289,700.00	3,231,630.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,851,000.00	14,588,200.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,851,000.00	14,588,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,895,700.00	13,632,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	955,300.00	955,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	799,724,600.00	789,877,755.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	769,274,900.00	761,848,392.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	769,274,900.00	761,848,392.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,449,700.00	27,845,963.00
132001	Орон нутгийн төсвөөс	30,449,700.00	27,845,963.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	6,154,182.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	(6,154,182.00)
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	183,400.00

	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	183,400.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53.00	53.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00
620004	Гэрээт ажилтан		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	661.00	661.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	661.00	661.00
630001	Төрийн өмчит ЕБС	661.00	661.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	53.00	53.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	38.00	38.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	8,670,847.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,470,847.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,470,847.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,258,200.00
210401	Бичиг хэрэг	-	1,233,200.00
210402	Тээвэр, шатахуун		

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,725,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,212,647.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,212,647.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,200,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,200,000.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	8,670,847.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,670,847.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,600,847.27
131105	төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
131106	Төсвийн урамшуулал		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээ ажилтан Б.Оюунтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 18 дугаар сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 18 дугаар сургууль нь хүүхэд нэг бүрийг хоцрогдолгүй сургахад бүх талын хамтын ажиллагааг өрөгжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын чанарт ахиц гарган, багшийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах зорилго бүхий ерөнхий боловсрол олгох, БШУЯ-ны харьяа төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан

төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт орлогын 820,074.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,301.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,610.7 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,929.6 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Дансны авлага			
Бараа материал	60,155.3	70,019.4	9,864.1
Үндсэн хөрөнгө	2,109,114.9	2,113,180.4	4,065.5
Нийт хөрөнгө	2,169,270.2	2,183,199.8	13,929.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,941,687.2	1,905,517.7	-36,169.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,941,687.2	1,905,517.7	-36,169.5

Бараа материалын данс 70,019.4 мянган төгрөг болж 9,864.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал буюу, сурах бичиг 2,190.4 мянган төгрөг, бичиг хэрэг, аж ахуйн материал 7,673.7 мянган төгрөгөөр худалдан авсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,113,180.4 мянган төгрөг болж 4,065.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн өмчийн газраас шилжүүлсэн хөрөнгө ба БСШУЯ-аас зарласан цахим багш төсөл хөтөлбөрөөр худалдан авсан хөрөнгө байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,905,517.7 мянган төгрөг болж 36,169.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 18 дугаар сургуулийн 2021 оны төсвийн төслийг 820,074.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 783,041.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,319.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 712.9 мянган төгрөг нийт 820,074.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 811,808.6 мянган төгрөгийг зарцуулж, 8,265.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 811,808.6 мянган төгрөг буюу 9.9 хувьтай байгаа нь, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,527.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 436.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 941.9 мянган төгрөг, хангамжийн материалын зардлыг 971.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,039.9 төгрөг, бусад урсгал шилжүүлэгийг 3,203.7 мянган төгрөг, норматив зардлыг 14.5 мянган төгрөг, томилолтын зардлыг 81.8 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 48.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт дансаар 8,670.8 мянган төгрөгийн орлого орсноос БСШУЯ-ны цахим багш төсөл хөтөлбөрөөр 8,000.0 мянган төгрөг, БСГ-аас 600.8 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн үнэ 70.0 мянган төгрөг орж ирсэнийг үйл ажиллагаандаа зарцуулан ажилласан.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн 18 дугаар сургууль нь 2021 онд нийт 138,359.6 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна, харин зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,873.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1		1				
Албан шаардлага	1	7,873.8	1	7,873.8			
Нийт дүн	2	7,873.8	2	7,873.8			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 480.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Бичиг хэргийн ажилтанг Улаанбаатар хотод архив бичиг хэргийн 4 хоногийн сургалтанд хамруулж томилолтын зардал олгохдоо 84.0 мянган төгрөг илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2018 оны "зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 301 дүгээр тушаалын 1-т "төрийн албан хаагчийн зам хоногийн зардлыг.... Улаанбаатар..... хотод 16,000 мянган төгрөгөөр, байрны зардлын хэмжээг..... Улаанбаатар..... хотод 53,000 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтооо

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт:

Бичиг хэргийн материал бөөн дүнгээр нэг алба хаагч дээр зарлагддаг, мөн няравын гаргаж байгаа бараа материалын тайланг нягтлан хянаж баталгаажуулдаггүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах.

1.3 Илрүүлэлт:

2021 оны 09 сарын 30-ны өдөр нярав солигдсон байтал эд хөрөнгийг тооллогыг зохион байгуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12.2.2.-д " Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед тооллого хийнэ", 12.1-д " Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Захирал, нягтлан бодогч, нярав солигдох үед эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байх.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 18-р сургууль	3				1	84.0			2	396.0